

TMC CONNECT

March 2015

АЖИЛЧИДЫН
МЭДЭЭ



Цагаан сарын баярын үйл ажиллагаа

2015 оны 2 сарын 16 өдөр ТМС ажилчид Бишан кампуст цагаан сарын баяраа тэмдэглэлээ. Гэрэл гэгээтэй, эрч хүч дүүрэн сарыг бэлгэдэж бүх ажилчид улаан цамц өмсөн 4 давхарын хурлын танхимд цуглалаа. Сургуулийн захирал Доктор Chin Kon Yuen гуай ажилчидтайгаа мэндчилж тэдэнд 2 ширхэг жүрж болон улаан дугтуйтай мөнгө бэлэглэлээ. Мөн үргэлжүүлэн биеийн тамирын талбайд бүгд BBQ үдэшлэг зохион байгуулсан юм.

ЗОЧИДЫН
БУЛАН

ГангВон их сургуулийн оюутнуудтай хамт хийсэн уламжлалт цайны өдөрлөг

2015 оны 1 сарын 26 өдөр манай хамтарч ажилладаг Ганг Вон их сургуулийн 6 оюутан Бишан кампуст зочилж ирэн ТМС академийн оюутнууд болон ажилчидтай хамт уламжлалт цайны өдөрлөгийг зохион байгууллаа.

Оюутнууд 1 давхарт ширээ засаг төрөл бүрийн солонгосын уламжлалт цай болон амттанг хүмүүст танилцуулж байлаа. Мөн тэд цай бэлдэж ТМС ын оюутны клубын гишүүд болон ажилчидад амсуулав. Түүний дараа гишүүд болон ажилчид тус өдөрлөгт оролцож буй зочидод цай амттангаар үйлчилсэн юм.



Өдөрлөг дууссаны дараа Ганг Вон их сургуулийн оюутнууд уламжлалт цайны талаарх асуултуудад хариулж цайны талаарх төрөл бүрийн мэдээллийг цугалсан олонтой хуваалцаж байсан юм.



Цагаан сарын баярын үйл ажиллагаа

2015 оны 2 сарын 19 өдөр буюу шинийн нэгний өдөр Доктор Chin оюутнууд болон ажилчидыг гэртээ урьлаа. Хамтдаа цагийг хөгжилтэй өнгөрөөж цагаан сарын бэлгээ ч солилцон өдрийн хоолоо хамтдаа идсэн юм. Энэхүү өдрийн хамгийн сайхан хэсэг нь хамтдаа цуглан шинэ сардаа аз хийморьтой байлгахыг хүсдэг 'Ло Хэй' ёс заншилыг үйлдсэн бөгөөд эсвэл шинэ сараа угтаж байна гэж үзэн 'Юү Шэнг' заншилыг ч үйлдсэн. Иймэрхүү ёс заншилыг анх удаа үйлдэж байгаа зочидод маш сонирхолтой үйл явдал болж өнгөрсөн юм.

'Юү Шэнг' гэдэг нь шинэ сард аз хийморьтой байлгадаг гэж үздэг ёс заншил учир уламжлал болгон байнга үйлддэг. Гэр бүл болон найз нөхөдтэйгээ хамт нэг ширээний ард сууж шинэ сардаа аз хийморьтой байхыг хүсэн хэрчиж бэлдсэн загас, лууван болон байцаа зэрэг хүнсний ногоог хооронд нь холин савхаараа хавчин хамтдаа дээш өргөн хооронд нь тулган аз хийморьтой байхыг хүсдэг. Хоол хавчсан савхаа өндөрт өргөх тусам аз хийморьтой байна гэж үздэг байна.



Шинэ оюутнуудад зориулсан зөвлөмж

TMC Академи нь 2015 оны 1 сард шинэ оюутнуудаа халуун дулаанаар хүлээн авлаа.

Сургалтын албанаас зарласан хугацаанд TMC академийн оюутны клуб шинэ элсэгчидэд зориулан тэдэнтэй илүү дотносох үүднээс нүүр хагарах болон багын ажиллагаатай холбоотой тоглоом, үйл ажиллагааг зохион байгуулсан юм. Ажилчид, болон оюутны клубын гишүүд хамтдаа шинэ оюутнуудтай танилцаж мөн оюутны амьдралд хурдан дасгах зорилготойгоор ярилцаж цагийг өнгөрөөсөн юм.

Та бүхэнтэй ярилцаж цагийг маш сонирхолтой өнгөрөөлөө. Дараагийн семестерт уулзахыг тэсэн ядан хүлээж байя!



TMC
Academy
Since 1981
Every Step With You

Issued By:
Marketing & Business Development Division
© 2015 TMC Academy
www.tmc.edu.sg | events@tmc.edu.sg



Cert No. : EDU-2-2006
Validity: 01/10/2012 - 30/09/2016



Гайхалтай Hawker ын баяр 2014



TMC Academy нь ашгын бус үйл ажиллагаа явуулдаг TOUCH Community Services ээс зохион байгуулсан гайхалтай Hawker ын баярт уригдсан юм. Энэхүү буяны үйл ажиллагаа нь Suntec Сингапурын үзэсгэлэнгийн төвд 2014 оны 11 сарын 22 нд зохион байгуулагдсан юм.

3000 гаруй хүмүүс төрөл бүрийн Hawker маягийн хоолыг худалдаж авахын тулд купон худалдаж аван түүгээрээ гахайн ясны шөл, лувантай бялуу, үндэсний springroll, эрүүл мэндийн матрын шөл, шувууны үүр ундаа, prawn гоймон, загастай гоймон, уурын талх, тахианы махтай будаа, шарсан нугас цагаан будаа шарсан гахайн мах зэргийг худалдаж аван идэж байсан юм. Зочид төрөл бүрийн хоолыг амталж үзэн цагийг зугаатай өнгөрөөж байлаа.

50 гаруй TMC ажилчид болон оюутнууд купон авсан зочидод тусалж, аяга тавгыг хурааж, зочидод стикэр өгөх зэрэг арын албаны ажлыг хийн тухайн үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулж байсан юм. Зочид буудал аялал жуулчлалын 6 оюутан VIP зочидыг ширээнд суулгаж хоолоор үйлчлэх зэрэг ажлыг даан хийж байлаа. Нийгмийн сайд гэр бүлийн хөгжлийн дарга Ноён Chan Chun Sing Захирал Dr Chin Kon Yuen д талархсанаа илэрхийлж тайзан дээр гаргасан юм.

Бүх купон сайн үйлсийн төлөө бүгд зарагдсан бөгөөд үйл ажиллагаа маань 5 цагт амжилттай болж өндөрлөсөн юм.

Цагаан сарын баярын үйл ажиллагаа



Төгсөгчид маань цагаан сарын үеэр бидэнтэй уулзахаа мартаагүй бөгөөд 2015 оны 2 сарын 21 өдөр Доктор Chin ны гэрт зочилж ирлээ. Удаан уулзаагүй найз нартайгаа уулзаж сар шинийн мэнд мэдэж цагийг хөгжилтэй өнгөрөөж байлаа. Тэд 'Юү Шэнг' үйлдэж, амттай өдрийн хоол идэн, шинэ сардаа эрүүл энх аз жаргалтай байлгах хүслээ шивнэлээ. Шинэ сараа угтах өдрөө төгсөгчидтэйгээ хамт байсандаа бид маш их аз жаргалтай байсан юм.



Old Age Home д зочиллов



ТМС төгсөгчид 2014 оны 12 сарын 21 өдөр Lee Ah Mooi Old Age Home д амьдарч байгаа хүмүүст зориулан зул сарын баярыг зохион байгуулж Санта аяныг явууллаа. ТМС төгсөгчид, оюутнууд, ТМС ажилчид гээд нийт 20 хүн оролцсон бөгөөд будаа, тос, хуурай хоол, насанд хүрэгчидийн живх, мөн төгсөгчид оюутнууд ажилчидаас цугларсан 534 сингапур долларыг хандивлалаа.

Тухайн үйл ажиллагаагаар сайн дурын ажилчид ч мөн ирсэн бөгөөд тэдэнд зөвхөн цүнхтэй бэлэг өгөхөөс гадна настай хүмүүст зориулан тэдний хүссэн сэдвээр ярилцаж цагийг хөгжилтэй өнөгөөж байлаа. Мөн сувилагч нар үзлэг хийж байсан сайн дурын

ажилчидын ачаар хүн бүртэй ярилцаж тэдний түүхийг нэг бүрчлэн сонсож чадаж байсан юм. Ярилцлагын дараагаар настангууд амттан болон солонгос амттан идэж цагийг хөгжилтэй өнгөрөөсөн юм. Мөн караокэдэж хамтдаа дуулж байсан бөгөөд үйл ажиллагаа маань санта клаус мөн бусад хүмүүсийн гэнэтийн бэлгээр өндөрлөсөн юм.

Сантагийн үйл ажиллагаа амжилттай өндөрлөсөн юм! Сайн дурын ажилчидтай хамт энэхүү үйл ажиллагаанд оролцсон бүх хүмүүстээ талархсанаа илэрхийлэе. Мөн бүх ажилчидад дурсамжтай мартагдашгүй цаг хугацаа болсон гэдэгт найдаж байна.

ТМС ACADEMY-ИЙН ТУХАЙ

TMC Academy нь 1981 онд Сингапур улсад байгуулагдсан. Бид та бүхэнд нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн Бизнес болон менежмент, Англи хэлний сургалт, GCE 'O' Level, Үйлчилгээ болон аялал жуулчлалын менежмент, Мэдээллийн технологи, Хууль, Сэтгүүл зүй болон Сэтгэл зүй зөвлөгөөний хөтөлбөрүүдийг санал болгож байна.

БИДНИЙ АЛСЫН ХАРАА

Амжилттай чадварлаг оюутнуудыг төгсгөж шилдэг сургууль болох.

БИДНИЙ ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид үйлдвэрлэлд тулгуурласан тухайн орчин нөхцөлд тохирсон мэдлэг боловсролыг санал болгож байна.

БИДНИЙ ГОЛ ЗҮЙЛ

Мэргэжлийн ур чадвар – Бид ёс суртахуун, хариуцлага, ил тод байдлын хамгийн дээд зэргээр баримталдаг.

Ойр байдал – Бид харилцааг эрхэмлэдэг бөгөөд бие биедээ гэр бүлийн гишүүд шиг тусалж дэмжихийг эрмэлздэг.

Тасралтгүй хөгжүүлэх – Бид хамгийн шилдэг нь байхын тулд тууштай байж мөн үргэлж өөрсдийгөө шинэчилж хөгжүүлж байдаг.

Бидний үүрэг – Бид ТМС Академийн элч нар бөгөөд бидний үүрэг бол ТМС академийг улам боловсронгуй болгож хөгжүүлэх юм.